



Ю. хонор тутмын хэвлэл  
оны 04 дүгээр сарын 05  
№13 /634/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг

401

Монгол Улсын  
Засгийн газрын  
тагтоол

403

Монгол Улсын Үндсэн  
хуулийн цэцийн  
дүгнэлт

410

**Шүүгч, Ерөнхий шүүгчийн  
албан тушаалд томилох тухай**

**Хилийн зарим боомтын талаар  
авах арга хэмжээний тухай**

**Гэр бүлийн тухай хуулийн  
57 дугаар зүйлийн 57.2 дахь  
хэсгийн заалт Үндсэн хуулийн  
холбогдох заалтыг зөрчсөн  
эсэх тухай маргааныг хянан  
шийдвэрлэсэн тухай**

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 108. | Шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 29 | 401 |
| 109. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай             | Дугаар 30 | 402 |
| 110. | Шүүхийн сахилгын хорооны гишүүнэж чөлөөлөх тухай    | Дугаар 37 | 402 |

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 111. | Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай                             | Дугаар 06 | 403 |
| 112. | Өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 07 | 405 |

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 113. | Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 01 | 410 |
|------|---|-----------|-----|

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2010 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

**Шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4, 32.6 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн, Ендонгийн



Цогтзанданг Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан, Одцэрэнгийн Однямааг Говьсүмбэр аймаг дахь Сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Бадамрагчаагийн Батболорыг Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

2010 оны 02 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар  
хот

**Шүүгчийн албан тушаалаас  
чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.2 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн, Одцэрэнгийн Однямааг төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Говьсүмбэр аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

2010 оны 03 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар  
хот

**Шүүхийн сахилгын хорооны гишүүнээс  
чөлөөлөх тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Ц.Түмэнбаярыг өөрийнх нь хүсэлтээр Шүүхийн сахилгын хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2010 оны 01 дүгээр  
сарын 08-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

**Хилийн зарим боомтын талаар  
авах арга хэмжээний тухай**

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Төсөв баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2009 оны 85 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Стратегийн ач холбогдолтой томоохон орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулан олборлож экспортлож байгаа нүүрсний хэмжээ эрс нэмэгдсэнтэй холбогдуулан "Гашуунсухайт", "Шивээхүрэн" боомтыг ачаа болон зорчигчдын хөдөлгөөний урсгалыг төрөлжүүлэн свадгүй нэвтрэх боломжтой, дэд бүтэц, суурин газар бүхий олон улсын жишигт нийцсэн хилийн боомт болгон өргөтгөх ерөнхий төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох төслүүдийн хамт 2010 оны I улиралд багтаан боловсруулж Засгийн газарт оруулахыг Сангийн сайд С.Баярцогт, Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт тус тус даалгасугай.

2. Дараахь арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, шаардагдах хөрөнгийг нь жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хувийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Монгол Улсын Шадар сайд М.Энхболд нарт даалгасугай:

а) "Гашуунсухайт", "Шивээхүрэн" боомтыг олон улсын жишигт нийцсэн хилийн боомт болгон барьж байгуулах, тээврийн хэрэгслийн жин, рентген болон шалган нэвтрүүлэх бусад тоног төхөөрөмж (гэрэлтүүлэг, дүрс бичлэг, (камер)-ийн хяналтын систем) суурилуулах, лаборатори, ариутгал халдваргүйтгэлийн цэг байгуулах;



б) байгаль, экологийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын "Цагаанхад" хэмээх газарт байгаа нүүрс ачиж буулгах цэгийн үйл ажиллагааг өөрчлөн байгаль орчинд сөрөг нөлөөгүй техник, технологи нэвтрүүлж, олон улсын стандарт, жишигт нийцсэн нүүрс шилжүүлэн ачиж байгууламж барьж байгуулах.

3. Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ-ын талтай яриа хэлэлцээ хийж "Гашуунсухайт", "Шивээхүрэн" боомтыг 2010 оны I улиралд багтаан 24 цагийн үйл ажиллагаатай олон улсын боомт болгох талаар холбогдох арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

4. "Гашуунсухайт", "Шивээхүрэн" хилийн боомтын үйл ажиллагаа 24 цагийн горимд шилжихтэй холбогдуулан хил, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагын орон тоог нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг судалж, 2010 оны I улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Сангийн сайд С.Баярцогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Монгол Улсын Шадар сайд М.Энхболд нарт даалгасугай.

5. Дараахь арга хэмжээг авч ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай:

а) ашигт малтмалын бүтээгдэхүүн экспортолж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан Тавантолгой орд газраас "Гашуунсухайт" болон "Ханги" боомт хүртэл автозам бариулах асуудлыг "Эрдэнэс МГЛ" компанид хариуцуулан автозам барихтай холбогдсон ажлыг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлэх;

б) дээрх автозамыг барьж дуусах хүртэлх хугацаанд одоо ашиглаж байгаа замын тэмдэг, тэмдэглэгээ, замын засвар арчлалтын ажлыг ашигт малтмалын бүтээгдэхүүн экспортолж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын хүчээр хийлгэх.

6. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр дэх ашигт малтмалын зарим орд газраас уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортолж байгаа аж ахуйн



нэгж, төрийн захиргаа болон нутгийн удирдлагын байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангаж, хилийн боомтын үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийг томилон ажиллуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ  
ХҮЧНИЙ САЙД**

**Д.ЗОРИГТ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2010 оны 01 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 07

Улаанбаатар  
хот

### **Өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Улсын нөөцийн тухай хуулийн 13.1.4, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. Өвөлжилтийн байдал хүндэрсэн Баян-Өлгий, Завхан, Увс, Ховд, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь, Төв аймаг дахь улсын нөөцийн цэг, салбаруудад хадгалагдаж байгаа 4000 тонн өвс, 5000 тонн тэжээлийн үнийг 50 хувиар хямдруулж худалдахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод зөвшөөрсүгэй.

2. Ховд аймгийн Булган, Хөвсгөл аймгийн Галт, Увс аймгийн Давст сумын хүн эмнэлэгт УАЗ-31512 маркийн автомашин тус бүр нэгийг улсын нөөцөөс олгож, энэ оны 4 дүгээр сард багтаан нөхөн бүрдүүлэхийг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод, дээрх гурван автомашины үнийг 2010 оны төсвийн багцаасаа гаргаж Онцгой байдлын ерөнхий газарт энэ оны I улиралд багтаан олгохыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад тус тус даалгасугай.

3. Улсын нөөцөөс 50 хувийн хөнгөлөлттэй үнээр худалдах өвс,



тэжээлийн үнийн зөрүү болох 870.97 сая төгрөг, орон нутгийн чанартай зам, давааны цэсыг арилгахад шаардагдах 97.4 сая төгрөг, хүндэрсэн сум, багуудад өвс, тэжээл хүргэх тээврийн зардалд 60.0 сая төгрөг, малчдад эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа автомашины шатахууны зардалд зориулж 60.0 сая төгрөг, нийт 1.088.370.000 (нэг тэрбум наян найман сая гурван зуун далан мянган) төгрөгийг энэхүү тогтоолын хавсралтын дагуу Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

4. Хямдралтай үнээр олгох өвс, тэжээлийг өвөлжилтийн нөхцөл байдалтай уялдуулан аймаг, сумдад хуваарилан борлуулах ажлыг зохион байгуулан, борлуулсан орлого болон Засгийн газраас олгох үнийн зөрүүгийн санхүүжилтээр өвс, тэжээл нэмж худалдан авч, 2010 оны 2 дугаар сард багтаан нөхөн бүрдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгасугай.

5. Улсын нөөцөөс хөнгөлөлттэй үнээр худалдах өвс, тэжээлийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авч ажиллахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

6. Цахилгаан станцуудад 20-иос доошгүй хоногийн нүүрсний нөөцийг бүрдүүлэх арга хэмжээг яаралтай авах, дулааны шугам сүлжээний дулааны алдагдлыг зогсоох, хаагдсан зам, давааны цэсыг арилгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт тус тус даалгасугай.

7. Эрчим хүчний салбарт энэ онд улсын төсвөөс олгох татаасыг батлагдсан хуваарийн дагуу 1 дүгээр сард багтаан санхүүжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**М.ЭНХБОЛД**

Засгийн газрын 2010 оны 07 дугаар  
тогтоолын хавсралт

**МАЛ ӨВӨЛЖИЛТИЙН БАЙДАЛ ХҮНДЭРСЭН ЗАРИМ  
АЙМГУУДАД ОЛГОХ ӨВС, ТЭЖЭЭЛ, ТЭЭВЭР, ШАТАХУУНЫ  
ЗАРДЛЫН ТООЦОО**

Дайчлан ажиллуулах зэвсэгт хүчин, хилийн цэргийн анги, байгууллага	Зэвсэгт хүчний 325-р анги, Хилийн цэргийн 0277-р анги
Зам, давааны нэр	Шилүүстэй, Цагаанчулуут, Даагат, Чандманы дөрөлж, Нөмрөгийн баруун даваа, Салхитын дөрөлж, Агуйтын, Теонтийн, Хатавчийн даваа
Орон нутгийн чанартай зам, давааны цэсыг арилгах зардал (сая.төг)	13.5
Орон нутагт нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа автомашины шатахууны зардал	5.0
Хүндэрсэн сум, багуудад өвс, тэжээл хүргэхэд шаардагдах тээврийн зардал (сая.төг)	5.0
Тэжээл (тн)	600
Өвс (тн)	700
Аймгийн нэр	Завхан
№	1



2	Увс	400	400	5.0	5.0	13.0	Хяргас нуурын арын зам, Улаан даваа	Хилийн цэргийн 0245-р анги Хилийн цэргийн 0311-р анги
3	Баян-Өлгий	800	400	5.0	5.0	8.2	Лагшингийн даваа, Даянгийн даваа, Шинэ даваа, Буриалдын даваа	Хилийн цэргийн 0165-р анги
4	Дундговь	300	400	5.0	5.0	1.2	Гангын даваа, Цастын даваа	-
5	Баянхонгор	300	500	5.0	5.0	5.5	Эрхтийн даваа	-
6	Говь-Алтай	300	200	5.0	5.0	12.0	Дөтлөн даваа, Бугатын даваа, Цагаан голын хөндийн зам	-
7	Төв	300	600	5.0	5.0	12.0	Хангайн даваа, Аадгайн даваа, Мэргэний даваа	-

8	Хөвд	400	100	5.0	5.0	23.0	Цахирын даваа, Барлагийн даваа	Зөвсэгт хүчний 123-р анги
9	Хөвсгөл	100	400	5.0	5.0	5.5	Цагаан бургасын даваа	Хилийн цэргийн 0284-р анги
10	Өвөрхангай	100	600	5.0	5.0	3.5	Бат-Өлзий сумын 2, 3 дугаар багийн даваа	Зөвсэгт хүчний 256-р анги
11	Өмнөговь	100	300	5.0	5.0	-	-	-
12	Архангай	200	500	5.0	5.0	-	-	-
Бүгд		870.97		60.0	60.0	97.4	-	-
Нийт				1,088.370.0			-	-



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2010 оны 03 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

**Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн  
57.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох  
заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан  
шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн  
хуралдааны танхим 12.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан /илтгэгч/, Ж.Амарсанаа, Д.Наранчимэг, Д.Мөнхгэрэл нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Г.Агар-Эрдэнийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Хуралдаанаар Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч, Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Тогтохжаргал, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Очирбат нар оролцов.

**Нэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Тогтохжаргал Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:**

"Монгол Улсын Үндсэн хуулийн Араан дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна" гэсэн заалтыг 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр батлагдаад одоо мөрдөж байгаа Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг зөрчсөн байна.

... Монгол Улсын иргэн 60 нас хүрмэгц иргэний унаган эрхээ алдаж, эрүүл мэнд, амьдралын бололцоо нэхцөл байсан ч хүсэл зорилгоо хуулиар хязгаарлуулж удам хойчоо залгуулах эрхээ алдаж байна.



Монгол Улсын Үндсэн хуулийн "нас"-аар ялгаварлан гадуурхаж болохгүй, хүн бүр эрх зүйн этгээд байна гэсэн заалт ноцтой үр дагавартайгаар зөрчигдөж байгаа юм.

Жаран нас хүрсэн иргэн нь "хүн" учир эрх зүйн этгээд байх Үндсэн хуулийн дээрх заалт ч мөн л зөрчигдөж байна. ...

... Монгол ёс заншилд хадгалагдан уламжилж ирсэн зүйлүүдийн нэг нь үр хүүхэд үрчлэн авч үр удмаа залгуулах, өв хөрөнгөө өвлүүлэх, төр нийгэмдээ хүн бойжуулж үлдээх явдал билээ. Энэ нь өмнөх хууль тогтоомжуудад ч хадгалагдсаар ирсэн. ...

... Одоо мөрдөгдөж байгаа гэр бүлийн тухай хуульд иргэнийг нас зааж хүүхэд үрчлэх эрхийг нь хассанаар удам залгуулах үр мөрөөдөн, боломж хайж байгаа биеийн эрүүл мэнд, эд хөрөнгийн боломжтой иргэнийхээ эрхийг хуулиар хасч байгаа төдийгүй эцэг, эх, асрамж хүсч байгаа өнчин хүүхдийн эрхийг давхар хязгаарлаж байна.

Түүнчлэн амьдралын золгүй явдлаас өнчирч үлдсэн хүүхдийг элдэв дарамт чирэгдэлгүй, ариун сайхан сэтгэл санаагаар өөрийн асрамждаа авч өсгөн бойжуулахаар үрчлэн авах иргэний үндсэн эрхийг боогдуулжээ...

... Миний бие ийнхүү ахмад настныг иргэнийхээ эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэснийг Үндсэн хуулиар тунхагласан иргэний үндсэн эрхийг зөрчсөн хэмээн үзэж байгаа бөгөөд харин хүүхэд үрчлэхэд харшлах заалтыг хуулиар тогтоохыг буруу хэмээн үзэхгүй байгаагаа дашрамд тайлбарлая.

Иймд Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь заалтаас "60-аас дээш настай..." гэсэн үгийг хасч иргэний хүүхэд үрчлэн авах эрхийг сэргээн тогтоох боломж олгохыг хүсэж ийнхүү өргөдөл гаргав" гэжээ.

**Хоёр. Дээрх өргөдлийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Л.Рэнчин урьдчилан шалгаж 2006 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 38 дугаар тогтоолоор маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан бөгөөд уг тогтоолын үндэслэлд:**

1. "Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд хүүхэд үрчлэх эрхийг 60 насаар хязгаарласан нь хүүхэд асарч, хүмүүжүүлэх үлэмж хүндрэлтэй, хариуцлагатай ажлыг 60 наснаас дээш настай хүмүүс гүйцэтгэхэд бэрхшээлтэй гэж үзсэнтэй холбоотой болов уу.



2. Хүүхэд асрах чадвар мөхөсдсөн настай хүнд хүүхэд үрчлүүлэх нь хүүхдийн эрх ашгийг хохироож болзошгүй гэж хууль тогтоогчид болгоомжилсон байх.

3. 1989 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн 44 дүгээр чуулганаар батлагдаж, манай улс 1990 онд нэгдэн орсон Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 4 дүгээр зарчимд "Хүүхдэд нөлөөлөх аливаа асуудлыг шийдвэрлэхдээ эн тэргүүнд хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангах ёстой", мөн Конвенцийн 3 дугаар заалтад "Хүүхдийн асуудлаар шийдвэр гаргахдаа эн тэргүүнд хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангахад анхаарлаа хандуулна" гэж заасан байна. Үүнээс үзвэл хууль тогтоогчид хүүхэд үрчлэх асуудлыг шийдэхдээ үрчлэн авч байгаа хүний эрх ашгаас өмнө хүүхдийн эрх ашгийг илүүд үзэж анхаарсныг буруутгах үндэслэл алга байна. Ер нь ч тэгээд аль ч эрх зүйд "нас" гэдэг яаж ч болдоггүй бодит үзүүлэлтийг үндэслэн ямар нэг асуудлыг насны байдалтай холбож ялгамжтай тогтоох явдал олонтаа байдаг бөгөөд энэ нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дэлхийн жишиг билээ.

Ингэж үзвэл иргэн Д.Тогтохжаргалын өргөдөлд дурдсан зүйл нь Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил биш байх тул Үндсэн хуулийн цэцэд харьяалан шийдвэрлэх маргаан биш байна" гэжээ.

**Гурав. Иргэн Д.Тогтохжаргал Цэцийн гишүүний дээрх тогтоолыг эс зөвшөөрч Үндсэн хуулийн цэцэд дахин хандаж гомдол гаргасан бөгөөд уг гомдолд:**

"... Цэцийн гишүүн миний өргөдлийн утга санааг өнгөц байдлаар дүгнэн "60-аас дээш настан хүүхэд асрахад бэрхшээлтэй гэж үзсэнтэй холбоотой болов уу" гэх буюу "хууль тогтоогчид болгоомжилсон байх" гэх мэт шалтгаан заан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсаныг үндэслэлгүй хэмээн үзэж гомдол гаргаж уг өргөдлийг дахин сэргээж авч үзэхийг хүсэж байна.

Би одоогийн мөрdej байгаа Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт 60-аас дээш настай хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглохоор заасан нь Үндсэн хуулийн заалт, утга агуулгыг ноцтой зөрчсөн байна гэсэн үндэслэлээ өмнөх өргөдөлд тодорхой дурдаж нотолсон тул энд давхардуулан бичсэнгүй" гэжээ.

**Дөрөв. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 6 дугаар багийн оршин суугч, иргэн Х.Хуандаг Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:**

"Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2

дахь хэсэгт "60-аас дээш настай ... хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно" гэж заасан нь хүний эрх, эрх чөлөөг үл хүндэтгэн хязгаарласан, 60-аас дээш настай хүнийг эрх хасуулсан, хязгаарлуулсан, сэтгэцийн өвчтэй, олон удаагийн ял шийтгүүлсэн, шүүхээс эрхээ хасуулж хязгаарлуулсан хүмүүсийн хэмжээнд хүргэж басамжилсан, 60-аас дээш настай хүнийг насаар нь дарамтлан ямар ч үндэсгүй эрхийг нь хассан заалт болсон гэж үзэж байна.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт "60-аас дээш настай..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн доорх заалтуудыг зөрчиж гарсан гэж үзэж байна. Үүнд:

- Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна".

- Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13/ дахь заалтад "халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчиж, 60 наснаас дээш настай хүний эрхийг ёс бусаар хассан заалт болсон байна гэж үзэж байна.

60 настай хүн хүүхэд үрчилж авахад ямар ч харшлах зүйл байхгүй. Харин ч өнчин өрөөсөн, амьдрал нь муу хүүхдийг үрчлэн авч, түүнийг зөв өсгөн хүмүүжүүлэх, амьдрахад нь туслах, эд хөрөнгө өвлүүлэн үлдээх сайн талтай. Түүнчлэн 60 нас хүрээд үхэхгүй шүү дээ.

Учир иймд Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт "60-аас дээш настай..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчиж гарсан гэж үзэж Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргаж байна" гэжээ.

**Тав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 2 дугаар магадлалын үндэслэх хэсэгт:**

1. Иргэн Д.Тогтожаргалын "Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчиж байна" гэсэн агуулга бүхий өргөдлийг Цэцийн гишүүн Л.Рэнчин шалгаад 2006 оны 6 дугаар сарын 27-ны өдөр "Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах тухай" 38 дугаар тогтоол гаргажээ. Үг



тогтоолын үндэслэх хэсэгт "...Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил биш байх тул Үндсэн хуулийн цэцэд харьяалан шийдвэрлэх маргаан биш байна" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалттай нийцэхгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт "60-аас дээш настай ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн эсэх талаар иргэн Д.Тогтохжаргалын гаргасан гомдол нь үндэслэлтэй байна" гэжээ.

**Зургаа. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Очирбат Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

"... Гэр бүлийн тухай хуулийн 57.2-ийн "60-аас дээш настай хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно" гэсэн заалт Үндсэн хуулийн дээрхи заалтыг зөрчөөгүй болно. Энэ нь дараахь үндэслэлтэй юм.

Улсын Их Хурлаас 1999 онд Гэр бүлийн тухай хуулийг баталж, энэхүү хуулиар хүндэтгэн үзэх шалтгаанаар эцэг эхийн асран хамгаалалтгүй болсон хүүхдийн эрхийг хамгаалах хэд хэдэн арга, хэлбэрийг тогтоож өгсөн билээ. Үүнд:

1. үрчлэлт,
2. асран хамгаалалт,
3. харгалзан дэмжих,
4. гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх.

Монгол Улс 1990 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон билээ. Ийнхүү конвенцийн дагуу үрчлэлтийн тогтолцоог хүлээн зөвшөөрдөг улс орон болохын хувьд дагаж мөрдөж байгаа хууль, журмын дагуу гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж, хүүхдийг үрчлүүлж бэйх үүргийг оролцогч улс хүлээж байна.

Мөн Монгол Улс соёрхон баталсан "Эдийн засаг, нийгэм, соёлын

эрхийн тухай олон улсын пакт"-ын 4 дүгээр зүйлд "аливаа улсаас энэхүү Пактын дагуу хангах ёстой эрхийг адлүүлэхдээ эдгээр эрхэд зөвхөн хуульд тодорхойлсон ёсоор хязгаарлалт тогтоож болох бөгөөд энэ нь тэдгээр эрхийн уг чанарт нийцсэн, ардчилсан нийгэмд гагцхүү нийтийн сайн сайхан байдалд туслах зорилготой байх ёстой гэдгийг энэхүү Пактад оролцогч улсууд хүлээн зөвшөөрөхөөр" тунхагласан юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2-т "Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно" гэж заасан билээ.

Конвенцийн болон Үндсэн хуулийн дээрхи заалтуудыг баримтлан Гэр бүлийн тухай хуулиар хүүхэд үрчлэн авагчид тавигдах шаардлагыг хуульчилжээ.

Дэлхийн бусад орны жишгээр ч гэсэн үрчлэн авагчид тавигдах шаардлагад санхүүгийн чадавхи, эрүүл мэндийн боломжоос гадна үрчлэн авагч ба үрчлүүлэгч хоёрын насны зохистой зөрүүг хуульчилсан байдаг юм.

Монголчуудын зан заншил, уламжлалт ёсыг хууль тогтоогч харгалзан үзэж бүтэн өнчин хүүхдийг буюу эцэг, эх нь хоёулаа, эсхүл өрх толгойлсон ганц бие эх /эцэг/ нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй болсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хууль ёсны асран хамгаалагч үгүй үлдсэн хүүхдийг төрөл, садангийн аль ч насны хүн үрчлэн авч асран хүмүүжүүлэх эрхийг хэвээр үлдээсэн болно. Үүнийг Гэр бүлийн тухай хуулийн 57.3 дахь заалтаар баталгаажуулсан юм." гэжээ.

### **ҮНДЭСЛЭЛ:**

Хуулиар тогтоосон хүүхэд үрчлэн авах шалгуурыг хангасан, эрх зүйн бүрэн чадамж бүхий Монгол Улсын иргэнийг "60-аас дээш настай" гэсэн үндэслэлээр түүний хүүхэд үрчлэн авах эрхийг хассан нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн





57.2 дахь хэсэгт "60-аас дээш настай, ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... нас, ... -вар нь ялгаварлан гадуурхаж үл болно"; мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт "60-аас дээш настай, ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...Хүн бүр эрх зүйн итгээд байна", Арван зургадугаар зүйлийн 13/ дахь заалтын "халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ..." гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн "60-аас дээш настай, ..." гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн 2010 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Ж.БЯМБАДОРЖ**

**ГИШҮҮД**

**Н.ЖАНЦАН**

**Ж.АМАРСАНАА**

**Д.НАРАНЧИМЭГ**

**Д.МӨНХГЭРЭЛ**

**Хаяг:**

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци,


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [tarii\\_medeel@parliament.mn](mailto:tarii_medeel@parliament.mn)

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 1

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.  
Утас 329487